

Түүх 3 : Бяцхан хүүхдүүдийг хайрладаг Есүс

Библийн эшлэл
[Матай 19:14]

Харин Есүс – Хүүхдүүдэд зөвшөөр.
Тэднийг Над дээр ирэхийг нь бүү хоригло.
Учир нь тэнгэрийн хаанчлал нь эдний адил хүмүүсийнх юм гээд.

Есүс шавь нарынхаа хамт Бурханы хаанчлалын үгийг тунхаглахаар Иудей тосгонд хүрч ирэв.

Есүсийг хаана ч явсан олон түмэн цуглардаг байв.

Тэдний дунд бяцхан хүүхдүүд ээ дагуулаад ирсэн ээж аавууд ч бас байлаа.

Хүүхдүүд Есүстэй уулзана гэж бодохдоо ихэд баярлаж байв.

Тэр тэнд байна! Есүс тэнд байна!

Хүүхдүүд үсрэн босоод Есүс руу гүйв.

Гэвч хүүхдүүд Есүстэй ойртохыг оролдоход шавь нар нь тэднийг болон эцэг эхийг нь Есүстэй ойртохоос болгоомжлон халхалж байв. Энэ үед бүх зүйлийг харж байсан Есүс шавь нараа зэмлэн ингэж айлдав.

“Хүүхдүүдэд Над руу ирэхийг нь зөвшөөр. Бүү хоригло. Учир нь Бурханы хаанчлал эдний адил хүмүүсийнх юм. Хайрт шавь нар минь, Би та нарт үнэнийг хэлье. Та нар Бурханы хаанчлалыг бяцхан хүүхдүүд адил хүлээн авах ёстой – хэрэв хүлээн авахгүй бол тийш ер орж чадахгүй.” гэж хэлэв. Есүс хүүхдүүд руу гараа сунган тэднийг тэвэрч, тэдэн дээр гар тавиад ерөөв. Есүс явсан газар бүртээ хүүхдүүдээс төвөгшөөлгүй хэзээд маш ихээр хайрлаж байсан гэдэг юм.



Бүтээлч байцгаая 1. Доорх асуултанд хариулаарай.

а. Есүс, хүүхдүүдийг Өөр рүү нь ирэхэд яагаад бүү хорь гэж хэлсэн бэ?

б. Есүс Өөр рүү нь ирсэн хүүхдүүдэд юу хийж өгсөн бэ?

с. Матай 19:13 эшлэлийг уншаад хариулаарай: Аав ээж нар нь хүүхдүүд ээ, Есүс рүү дагуулж ирэхдээ Есүсээс юу хүссэн бэ?

● Дараах библийн эшлэлийг уншаад цээжлээрэй. (Матай 19:14)

Харин Есүс – Хүүхдүүдэд зөвшөөр. Тэднийг Над дээр ирэхийг нь бүү хоригло.
Учир нь тэнгэрийн хаанчлал нь эдний адил хүмүүсийнх юм гээд.

Бүтээлч байцгаая 2.

1-10 гэсэн дугаараас Есүстэй үулзах боломжтой нэг дугаарыг олоорой. Зүүнээс баруун тийш явж, босоо шугамтай таарвал дээш эсвэл доош чиглэлтэйгээр шилжиж Есүстэй үулзаарай.

